



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
2021 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН
БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022 он

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
(2021 оны жилийн эцсийн байдлаар)

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, удирдлагыг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээг үнэлэхдээ дараах 4 үзүүлэлт тус бүрийн хэрэгжилтийг гаргаж, дундаж үнэлгээгээр гэрээний үүргийн биелэлтийг тооцож гаргасан болно. Үүнд:

1. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний хэрэгжилт
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт
3. Улсын төсвөөс болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төсвийн гүйцэтгэл
4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний гүйцэтгэл

3.1 Хамтран ажиллах гэрээний биелэлт


Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээг 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр байгуулж, гэрээнд 8 чиглэлээр нийт 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Үүнд:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр 14 арга хэмжээ
2. Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр 7 арга хэмжээ

3. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр 4 арга хэмжээ
4. Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр 5 арга хэмжээ
5. Аймгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээний чиглэлээр 9 арга хэмжээ
6. Эрүүл мэндийн байгууллагад цахим мэдээллийн технологи нэвтрүүлэх чиглэлээр 4 арга хэмжээ
7. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр 5 арга хэмжээ
8. Бусад үйл ажиллагааны чиглэлээр 5 арга хэмжээ

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн дундаж дүн 81.2 хувьтай буюу 4.1 оноотой үнэлэгдэв. Энэ нь “тодорхой үр дүнд хүрсэн” буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүнд гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнд нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үг юм. Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг Нийслэлд 87.3 хувьтай, Архангай аймагт 86.4 хувьтай, Баянхонгор аймагт 85,5 хувьтай биелүүлсэн бол Баян-Өлгий, Орхон аймгууд хамгийн бага буюу 77.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Зураг 1. Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хувь



Аймаг, нийслэлийн хувьд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан 8 чиглэлээс Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа хамгийн өндөр буюу 87.0 хувьтай хэрэгжилттэй байсан бол Эрүүл мэндийн байгууллагад цахим мэдээллийн технологи нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа 65.4 хувийн хэрэгжилттэй байгаа нь цаашид энэ чиглэлээр үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэсэн үг юм.

3.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас Засаг дарга нартай 2021 онд хамтран ажиллах гэрээний 1 дүгээр хавсралтад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын 23 үзүүлэлтээс гадна хүний нөөц, сургалт, нийгмийн баталгаа, орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан санхүүжилт зэрэг тусгай шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан байна.

2021 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт дунджаар 80.4 хувь буюу 4.0 оноотой үнэлэгдэв. Энэ нь “тодорхой үр дүнд хүрсэн” буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үг юм. Шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу суурь түвшин, хүрэх түвшинг тодорхойлж хэрэгжилтийг тооцон гаргасан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийг урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг; эх, хүүдийн эрүүл мэнд; хүн амын нас баралттай холбоотой үзүүлэлт гэсэн 3 ерөнхий багц үзүүлэлтийг харьцуулан гаргалаа.

3.2.1 Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг

1. Урьдчилан сэргийлэх үзлэг

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 16 651 444 эмчийн үзлэг хийгдсэнээс 30.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 48.7 хувийг өвчний учир амбулаторт, 9.3 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 11.5 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Нэг их эмчид ногдох үзлэгийн тоо 1340 байна.

Хүснэгт 1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, аймгаар

Аймаг хот	Нийт үзлэг	Үүнээс					Эмчлэгдсэн хүний тоо	Ор хоног	Дундаж ор хоног	Бүртгэгдсэн өвчлөл		
		Урьдчилан сэргийлэх үзлэг	Өвчний учир амбулаторт	Идэвхитэй хяналт	Гэрийн идэвхитэй	Гэрийн дуудлаг-аар				2020 онд	2021 онд	5 жилийн дундаж
1. Архангай	346509	164183	118027	34400	22956	6943	24142	180680	7.5	74473	55834	70559
2. Баян-Өлгий	526146	197891	209005	51569	47811	19870	30307	217828	7.2	56709	77000	51008
3. Баянхонгор	275467	95597	89560	41719	43477	5114	30823	229721	7.5	81026	59267	76145
4. Булган	206722	81881	92209	18781	10748	3103	15433	122610	7.9	28025	46715	44084
5. Говь-Алтай	271151	104258	123365	16034	22039	5455	18882	156851	8.3	57667	42661	43281
6. Говьсүмбэр	101753	34356	53610	10328	3390	69	7200	54274	7.5	4583	4203	5254
7. Дархан-Уул	629070	205295	248615	43713	127828	3619	35865	267348	7.5	42656	36741	53243
8. Дорноговь	442529	167992	163877	62133	40981	7546	20618	164554	8.0	85945	72938	79875
9. Дорнод	401174	165580	155718	43709	30926	5241	23780	190179	8.0	38008	44200	41384
10. Дундговь	156578	67048	60066	20703	7417	1344	13450	109808	8.2	34699	23879	26255
11. Завхан	347450	134810	136722	28885	33003	14030	20466	163193	8.0	60045	55447	53474
12. Орхон	671736	268320	204492	55637	140721	2566	36694	255362	7.0	59716	55305	46760
13. Өвөрхангай	350849	124142	150395	41040	24963	10309	27932	216069	7.7	56473	43132	58449
14. Өмнөговь	331896	137145	118925	55517	16415	3894	18402	135455	7.4	80300	56649	67551
15. Сүхбаатар	195765	62324	74195	42961	9147	7138	16062	137162	8.5	37026	25441	33398
16. Сэлэнгэ	358892	108034	157286	68372	21521	3679	23922	182567	7.6	42374	36946	37590
17. Төв	289641	140250	112151	24219	10609	2412	19405	154531	8.0	83716	59048	79572
18. Увс	393558	131384	192255	34612	24515	10792	21713	157161	7.2	65773	66634	58850
19. Ховд	393496	116090	162126	64695	43756	6829	26398	214450	8.1	64523	57801	56311
20. Хөвсгөл	487871	200341	204737	50187	23995	8611	32577	239784	7.4	93307	78101	82901
21. Хэнтий	351760	136692	144790	41065	19567	9646	23518	190224	8.1	57319	59408	51296
Аймгийн дүн	7530013	2843613	2972126	850279	725785	138210	487589	3739811	7.7	1204363	1057350	1117239
22. Улаанбаатар	9121431	2234450	5129972	698435	1027229	31345	442757	3252125	7.3	1233980	1091366	1137544
Улсын дүн	16651444	5078063	8102098	1548714	1753014	169555	930346	6991936	7.5	2438343	2148716	2254783

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урьдчилан сэргийлэх үзлэг 2.0 хувиар өсч, гэрийн үзлэг 1.9, идэвхитэй хяналт 0.1 хувиар буурч, өвчний учир амбулаторийн үзлэг өмнөх оны мөн үетэй ижил байна. 2021 онд нийт 5 078 063 урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс Улаанбаатарт 2 234 450, орон нутагт 2 843 613 үзлэг хийгдсэн байна. Орон нутагт урьдчилан сэргийлэх үзлэгээр Орхон аймаг 268 320, Дархан-уул 205 295, Хөвсгөл 200 341 үзлэг зохион байгуулж ажилласан байна.

2. Эрт илрүүлэг

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 963 173 (46.6%) хүн хамрагдсан бөгөөд 42.1 хувь нь эрэгтэй, 57.9 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.9 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 40-өөс дээш насны нийт 801 070 (82.4%) хүн хамрагдсанаас 42.3 хувь нь эрэгтэй, 57.7 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 182 270 (21.6%) хүн хамрагдсанаас 122 тохиолдолд хорт хавдар оношлогдсон байна.

3.2.2 Эх, хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүд

1.Эхийн эндэгдлийн түвшин

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар эхийн эндэгдлийн 68 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 94.9 ногдож байна. Энэ нь өнгөрсөн оноос 45 тохиолдлоор их байгаа бөгөөд эндэгдлийн 46 тохиолдол нь коронавирусын шалтгаанаар эндсэн байна.

Хүснэгт 2. Эхийн эндэгдэл, 2020-2021 оны жилийн эцсийн байдлаар, аймагаар


Аймаг хот	Эхийн эндэгдэл /бодит тоо/		Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд/		
	2020 онд	2021 онд	2020 онд	2021 онд	5 жилийн дундаж
1. Архангай	2	4	122.0	242.4	104.2
2. Баян-Өлгий	5	2	174.6	68.3	55.0
3. Баянхонгор	0	1	0.0	53.8	9.9
4. Булган	0	0	0.0	0.0	0.0
5. Говь-Алтай	0	0	0.0	0.0	0.0
6. Говьсүмбэр	0	0	0.0	0.0	0.0
7. Дархан-Уул	0	3	0.0	136.7	43.5
8. Дорноговь	1	1	68.4	68.6	28.7
9. Дорнод	0	3	0.0	167.6	41.6
10. Дундговь	0	0	0.0	0.0	0.0
11. Завхан	0	1	0.0	75.2	44.0
12. Орхон	0	1	0.0	39.7	7.7
13. Өвөрхангай	1	1	41.2	45.3	24.9
14. Өмнөговь	0	0	0.0	0.0	12.8
15. Сүхбаатар	0	0	0.0	0.0	30.3
16. Сэлэнгэ	0	2	0.0	123.2	47.1
17. Төв	0	2	0.0	177.1	35.4
18. Увс	0	0	0.0	0.0	10.3
19. Ховд	1	3	44.0	147.4	80.7
20. Хөвсгөл	2	1	73.3	37.7	43.2
21. Хэнтий	0	0	0.0	0.0	13.2
Аймгийн дүн	12	25	32.9	70.9	34.2
22. Улаанбаатар	11	43	27.7	118.1	44.8
Улсын дүн	23	68	30.2	94.9	39.7

Архангай аймагт 4, Дархан-уул, Дорнод, Ховд аймгуудад тус бүр 3, Баян-Өлгий, Сэлэнгэ аймгуудад тус бүр 2, Баянхонгор, Дорноговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгуудад тус бүр 1 эх эндсэн бол Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Хэнтий зэрэг аймагт эхийн эндэгдэл бүртгэгдээгүй ажилласан байна.

2. Нялхсын эндэгдлийн түвшин

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар нялхсын эндэгдлийн 829 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 11.6 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 49 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 71.3 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 8.2 байна. Нярайн эндэгдлийн нийт 591 тохиолдлын 452 буюу 76.5 хувь нь эрт үеийн эндэгдэл, 139 буюу 23.5 хувийг хожуу үеийн эндэгдэл тус тус эзэлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг аймгуудаар харьцуулбал: Завхан (19.5), Ховд (18.2), Говь-Алтай (17.7), Баян-Өлгий (16.4), Төв (15.1), Булган (14.3), Дундговь (14.0), Хөвсгөл (13.6), Орхон (12.3) аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна.

Зураг 2. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, аймгаар




3. Жирэмсний хяналт

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар жирэмсний хяналтад шинээр 65 760 эмэгтэйчүүд хамрагдсан ба 90.6 хувь нь эхний 3 сартайд, 8.7 хувь нь 4-6 сартайд, 0.7 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад орсон байна. Хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.3 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 4.0 хувь нь цус багадаалттай байсан байна. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 91.4 хувь, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 91.4 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 98.7 хувь, ХДХВ/ ДОХ илрүүлэх шинжилгээнд 98.5 хувь нь хамрагдсан байна.

Жирэмсний эрт хяналтын хувьд Орхон аймаг 96.8 хувьтай тэргүүлж, Увс аймаг 96.0 хувьтай удаалж, улсын дундаж 92.6 хувьтай байна.

Зураг 3. Жирэмсэний эрт хяналтын хувь, аймгаар



3.2.3 Хүн амын нас баралттай холбоотой үзүүлэлтүүд

2021 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нас баралтын 19 929 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4007 тохиолдлоор өссөн байна. Нийт нас баралтын 11 760 тохиолдол буюу 59.0 хувь нь эрэгтэй, 8 169 буюу 41.0 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 34.8 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 1 285 тохиолдол буюу 18.5 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралтын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 6.2 байна. Нас баралтын 4.2 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5.0 хувийг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 3025 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 15.2 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 290 тохиолдлоор өссөн бөгөөд 10 000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 9.4 байна. Гаднын шалтгаант нас баралтад эзлэх хувиас харахад зам тээврийн ослоор нас баралт Улаанбаатарт 15.5 хувь, орон нутагт 26.9 хувьтай байна. Амиа хорлолт Улаанбаатарт 15.9 хувь, орон нутагт 20.9 хувь, үүнээс Хэнтий, Хөвсгөл, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Сэлэнгэ аймгуудад өндөр байна. Бусдад хорлогдсон нас баралт Улаанбаатарт 8.4 хувь, орон нутагт 4.1 хувь байгаагаас Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудад 10.3-10.5 хувь байгаа нь улсын дунджаас 3.7 хувиар их байна.

Хүснэгт 3. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтад эзлэх хувь, аймгаар

№	Аймаг/хот	Амиа хорлолт	Бусдад хорлогдсон	Үйлдвэрийн осол	Зам тээврийн осол	Бусад осол	Тодорхойгүй
А	Б	1	2	3	4	5	6
1	Архангай	20.0	5.3	1.1	26.3	47.4	0.0
2	Баян-Өлгий	15.1	1.9	0.0	43.4	37.7	1.9
3	Баянхонгор	29.4	5.9	0.0	29.4	35.3	0.0
4	Булган	29.3	7.3	0.0	29.3	34.1	0.0
5	Говь-Алтай	27.8	5.6	0.0	18.5	48.1	0.0
6	Говьсүмбэр	21.1	10.5	0.0	21.1	47.4	0.0
7	Дархан-Уул	16.0	0.0	4.0	12.0	68.0	0.0
8	Дорноговь	14.8	9.3	1.9	22.2	51.9	0.0
9	Дорнод	13.5	5.8	0.0	40.4	38.5	1.9
10	Дундговь	16.7	5.6	0.0	19.4	58.3	0.0
11	Завхан	17.6	0.0	0.0	29.4	52.9	0.0
12	Орхон	12.6	5.3	1.1	10.5	68.4	2.1
13	Өвөрхангай	19.4	3.0	1.5	32.8	43.3	0.0
14	Өмнөговь	19.6	2.0	0.0	31.4	47.1	0.0
15	Сүхбаатар	10.3	10.3	0.0	38.5	41.0	0.0
16	Сэлэнгэ	28.4	1.4	0.0	17.6	52.7	0.0
17	Төв	11.7	2.6	2.6	29.9	51.9	1.3
18	Увс	33.8	1.5	0.0	33.8	30.8	0.0
19	Ховд	20.0	2.5	0.0	45.0	32.5	0.0
20	Хөвсгөл	24.3	4.7	0.0	17.8	53.3	0.0
21	Хэнтий	32.2	0.0	1.7	33.9	32.2	0.0
22	Аймгийн дундаж	20.9	4.1	0.7	26.9	47.0	0.4
23	Улаанбаатар	12.7	8.4	0.2	8.1	64.8	5.8
24	Улсын дундаж	15.9	6.7	0.4	15.5	57.8	3.7


3.3 Төсөв, санхүүжилт

Эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэлийг 2021 оноос хэрэгжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэхээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг 2021 оны 3 дугаар сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн ба улсын 72 эмнэлэг, хувийн 192 эмнэлэг, Өрхийн 212 эрүүл мэндийн төв, Сумын 323 эрүүл мэндийн төвд болон бусад зардалд улсын төсвөөс 394,7 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,274.1 тэрбум төгрөгийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын дагуу 2021 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудад дараах үндсэн чиглэлээр сонгон шалгаруулалтыг зарлаж, гэрээ байгуулан санхүүжилт олгож ажилласан.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нь Эрүүл мэндийн салбарт эхний жилдээ хэрэгжиж байгаа шинэ төлбөрийн арга бөгөөд эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн даатгалын байгууллагууд тусламж үйлчилгээг бүртгэх, санхүүжилтийг нэхэмжлэх, хянах, олгох талаар туршлага хомс, ачаалал их байсантай холбоотой салбарын хэмжээнд жилийн эцсийн байдлаар он дамжсан өглөг үүссэн байна. Энэ нь зарим эрүүл мэндийн байгууллагууд тусламж үйлчилгээ үзүүлсэн зардлаа даатгалын сангаас нэхэмжилсэн боловч оны сүүлийн улиралд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн зардал олгогдоогүйтэй холбоотой байна.

Зураг 4. Эрүүл мэндийн байгууллагуудад үүссэн өглөг, 2021 оны жилийн эцсийн байдлаар




Орон нутагт 7 эмнэлэг 2.3 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүсгэснээс Сэлэнгэ аймагт Нэгдсэн эмнэлэг 1.2 тэрбум, Мандал сумын хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 117.7 сая төгрөг, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношологоо эмчилгээний төв 751.4 сая төгрөг, Хархорин сумын хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 31.2 сая төгрөг, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 46.0 сая төгрөг, Төв аймгийн нэгдсэн эмнэлэг 150.0 сая төгрөг, Ховд аймгийн Булган сумын хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 9.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүйгээс өр үүссэн байна.

Улаанбаатарт Хүрээ амаржих газар 1.5 тэрбум төгрөг, Өргөө амаржих газар 335.2 сая төгрөг, нийт 1.8 тэрбум төгрөгийн өр үүсэн байна. Эдгээр олгогдоогүй санхүүжилтийг 2022 он гарсаар он дамнуулж бүгдийг шийдвэрлэсэн боловч энэ нь 2021 онд гүйцэтгэлээр санхүүждэг тухайн байгууллагын үйл ажиллагааны санхүүжилт тасалдаж, өр үүсгэсэн тул энэ онд анхаарч байгууллагын дотоодод менежментийг сайжруулж ажиллах нь зүйтэй.

3.4 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний гүйцэтгэл

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн дундаж дүн 71.2 хувьтай байна.

Зураг 5. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэл /хувиар, аймаг, нийслэлээр/



Эрүүл мэндийн сайд нь Төсвийн тухай хуулийн 14.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.3 дахь заалтыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн байна. Хамтран ажиллах гэрээнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг бүрэн гүйцэтгэж ашиглалтад оруулсан Булган, Дорноговь, Орхон аймгууд байгаа бол Хөвсгөл аймгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 35 хувьтай байгаа нь хамгийн бага гүйцэтгэлтэй байна. Харин Говьсүмбэр аймагт 2021 онд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ батлагдаагүй байна. 2021 онд Коронавируст халдварын цар тахлын үед хил, гаалийн хорио цээр болон үе шаттай хэрэгжүүлсэн өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд барилга угсралтын ажил хэвийн явагдаж чадаагүй мөн барилгын бараа материалын үнийн өсөлттэй холбоотойгоор төлөвлөсөн барилгууд цаг хугацаандаа ашиглалтад орох боломжгүй зэрэг шалтгаан нөхцөл үүссэн байна.

Мөн Засгийн газрын 15 дугаар тогтоолын 2-р хавсралт, Эрүүл мэндийн сайдын "Эрх шилжүүлэх тухай" тушаалуудын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга

нарт худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлж, 120.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлж, санхүүжилтийг олгосон байна.

3.5 Нэгдсэн үнэлгээ

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийн дундаж 82.2 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн ба үзүүлэлт тус бүрээр харуулбал:

1. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний хэрэгжилт 81.2 хувь
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 80.4 хувь
3. Улсын төсвөөс болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төсвийн гүйцэтгэл 95.1 хувь
4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний гүйцэтгэл 71.2 хувь

Хүснэгт 4. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт

№	Аймгийн нэр	ЭМТҮ-ний чанарын үзүүлэлтийн биелэлт		Төсөв		Хөрөнгө оруулалт		ЗД гэрээний хэрэгжилт		Үнэлгээ	
		Хувь	Оноо	Хувь	Оноо	Хувь	Оноо	Хувь	Оноо	Хувь	Оноо
1	Архангай	86.8	4.3	100.0	5.0	73.3	3.7	86.4	4.3	86.6	4.3
2	Баян-Өлгий	79.9	4.0	100.0	5.0	72.5	3.6	77.7	3.9	82.5	4.1
3	Баянхонгор	76.0	3.8	90.0	4.5	69.0	3.5	85.5	4.3	80.1	4.0
4	Булган	83.0	4.2	90.0	4.5	80.0	4.0	81.3	4.1	83.6	4.2
5	Говь-Алтай	86.3	4.3	100.0	5.0	85.0	4.3	79.3	4.0	87.6	4.4
6	Говьсүмбэр	78.3	3.9	100.0	5.0	***	***	85.1	4.3	87.8	4.4
7	Дархан-Уул	80.1	4.0	100.0	5.0	82.0	4.1	83.4	4.2	86.4	4.3
8	Дорноговь	76.5	3.8	87.0	4.4	100.0	5.0	78.1	3.9	85.4	4.3
9	Дорнод	74.4	3.7	100.0	5.0	55.0	2.8	82.0	4.1	77.8	3.9
10	Дундговь	83.4	4.2	100.0	5.0	71.0	3.6	78.5	3.9	83.2	4.2
11	Завхан	77.1	3.9	90.0	4.5	75.0	3.8	79.9	4.0	80.5	4.0
12	Орхон	81.4	4.1	100.0	5.0	80.0	4.0	77.7	3.9	84.8	4.2
13	Өвөрхангай	82.8	4.1	80.0	4.0	80.0	4.0	79.7	4.0	80.6	4.0
14	Өмнөговь	77.1	3.9	100.0	5.0	58.0	2.9	79.3	4.0	78.6	3.9
15	Сүхбаатар	83.8	4.2	100.0	5.0	60.0	3.0	81.8	4.1	81.4	4.1
16	Сэлэнгэ	78.0	3.9	80.0	4.0	80.0	4.0	82.0	4.1	80.0	4.0
17	Төв	72.0	3.6	90.0	4.5	77.5	3.9	80.6	4.0	80.0	4.0
18	Увс	80.3	4.0	100.0	5.0	62.0	3.1	81.5	4.1	80.9	4.0
19	Ховд	79.7	4.0	95.0	4.8	50.0	2.5	79.7	4.0	76.1	3.8
20	Хөвсгөл	87.1	4.4	100.0	5.0	35.0	1.8	80.1	4.0	75.6	3.8
21	Хэнтий	85.6	4.3	100.0	5.0	75.0	3.8	80.4	4.0	85.3	4.3
22	Нийслэл	79.7	4.0	90.0	4.5	75.0	3.8	87.3	4.4	83.0	4.1
	Дундаж	80.4	4.0	95.1	4.8	71.2	3.6	81.2	4.1	82.2	4.1

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж

- Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2021 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг 82.2 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэлээ. Үүнд:
 1. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээ 81.2 хувьтай хэрэгжсэн байна.
 2. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт дунджаар 80.4 хувийн хэрэгжилттэй байна.
 3. 2021 онд улсын төсвөөс болон Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжих санхүүжилтийн гүйцэтгэл 95.1 хувь байна.
 4. 2021 онд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээ 71.2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.
- Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 930 346 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 6 991 936 ор хоног ашигласан байна. Улсын дунджаар ор ашиглалтын хувь 70.7, дундаж ор хоног 7.5 байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 94 069, ор хоног 1 186 188 тохиолдлоор тус тус өссөн байна. Тайлант онд ийнхүү Коронавируст халдвар /КОВИД-19/-тай холбоотой эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо өсч, эмнэлгийн ачаалал их байсан ч хамтран ажиллах гэрээнд тусгагдсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт өнгөрсөн оноос 8.5 хувиар нэмэгдсэн байна.
- Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээний 3 дугаар хавсралтаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 71.2 хувьтай буюу өнгөрсөн оноос 27 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2021 онд Коронавируст халдварын цар тахлын үед хил, гаалийн хорио цээр болон үе шаттай хэрэгжүүлсэн өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд барилга угсралтын ажил хэвийн явагдаж чадаагүй мөн барилгын бараа материалын үнийн өсөлттэй холбоотойгоор төлөвлөсөн барилгууд цаг хугацаандаа ашиглалтад орох боломжгүй нөхцөл үүссэнтэй холбоотой байна. Анхаарах асуудлууд:
 - Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо орон нутгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээний үнэлгээ хийж, тусламж, үйлчилгээний төлөвлөлт хийх, аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг тогтоон тусгай зөвшөөрөл шинээр олгох байршил, төрлийг тогтоох
 - Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилтийн мөнгөн дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тодорхой, тоо баримттай тайлагнах

- Хамтран ажиллах гэрээнд тусгагдсан, эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
- Хүн амын нас, эрүүл мэндийн байдал, эрсдэлтэй уялдуулан хэрэгжүүлж буй эрт, илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах, өвчлөл илэрсэн тохиолдлыг эмнэлгийн хяналтад авч эрүүлжүүлсэн байдалд хяналт тавьж, үр дүнг тооцох
- Гэрээнд тусгагдсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг гаргахдаа тайлант жилийг өмнөх онтой харьцуулан гаргаж, дүн шинжилгээ хийж ирүүлж байх
- Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг тайлагнахдаа төсөв санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хувиар гарган, танилцуулгын хамт ирүүлж байх
- Эрүүл мэндийн байгууллагад цахим мэдээллийн технологи нэвтрүүлэх чиглэлээр анхаарч ажиллах, цаашид энэ чиглэлээр үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хагас, бүтэн жилээр цахим хэлбэрээр цаг хугацаанд нь ирүүлж хэвших

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2022 оны 03 дугаар сарын 25

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ШИЙДВЭР

2022 оны 03 дугаар сарын 25

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2021 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2021 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг 82.2 хувь гэж үнэлэх.
2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг танилцуулгын хамт 2022 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд аймаг, нийслэлийн үзүүлэлт тус бүрээр мэдээлэл байршуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгох.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Ц.ЭРДЭМБИЛЭГ



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ц.НЯМДОРЖ ТАНАА**

2022.03.30 № 1а/1412

танай _____-ны № _____-т

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний
дүн хүргүүлэх тухай**

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай 2021 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хүргүүлж байна. Хавсаргасан:

1. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай 2021 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга
2. Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр

Хавсралт ¹⁴ хуудас



С.ЭНХБОЛД

141422338



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

2022.03.30 № 1а/1418

танай _____-ны № _____-г

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГА НАРТ

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2021 онд хамтран ажиллах гэрээний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хүргүүлж байна.

Хавсралт хуудас



С. Амьтсүрэн /ЭНХБОЛД

141522332